

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТАНИЛЦУУЛГА	6
1.1.ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	6
Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Чайна Тисижу Сивил Инженеринг Групп” ХХК	6
1.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ.....	8
БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ	11
2.1.БАЙГАЛЬ ОРЧНЫ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ	11
2.2. НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ	11
2.2.1. Сонгинохайрхан дүүрэг	11
2.2.2. Сонгинохайрхан дүүргийн газар ашиглалтын хэмжээ	12
2.2.3. Хүн амын усны хэрэглээ, хангамж.....	12
2.2.4. Аж ахуйн нэгжийн усан хангамж	13
2.2.5. Гэр хорооллын дахин төлөвлөлт	13
2.2.6. Инженерийн дэд бүтцийн төлөвлөлт	14
2.2.7. Харгиа бохир цэвэрлэх байгууламж.....	15
2.2.8. Цэвэрлэх байгууламжаас хүн амд үзүүлж буй нөлөөлөл.....	15
2.2.9. Хүн амын эрүүл мэнд	16
БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	17
3.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
3.2. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
3.3.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ	19
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ	30
ХАВСРАЛТ 1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ХЭМЖЭЭНҮҮД	31
ХАВСРАЛТ 2. ДЭЭЖИЙН ХАРИУ	34
ХАВСРАЛТ 3. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНҮҮД	36
ХАВСРАЛТ 4. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНҮҮД	39
ХАВСРАЛТ 5. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮД	48
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	
Хүснэгт 1. Төслийн хүрэх үр дүн	6
Хүснэгт 2. Төслийн төлөвлөгөө	8
Хүснэгт 3. 2023 оны БОМТөлөвлөгөөний биелэлтийн зардлын задаргаа	17
Хүснэгт 4. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал	18
Хүснэгт 5. 2023 оны байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал ...	18
Хүснэгт 6. 2023оны БОМТөлөвлөгөөний биелэлтийн зардлын задаргаа	18
Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт	19

Хүснэгт 8. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	23
Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	24
Хүснэгт 10. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 11. Байгаль орчны төлөвлөгөөт аудитын зардал	26
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	26
Хүснэгт 13 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг	7
Зураг 2. Төслийн талбайн өнөөгийн байдал	10

ОРШИЛ

Улаанбаатар хотын “Төв цэвэрлэх байгууламж” нь анх 1964 онд ашиглалтад орсон ба Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт 17.6 га талбайд байрладаг. Тус байгууламжийн хүчин чадал нь 150 000м³/өдөр ба нийслэлийн хүн амын төвлөрөл ихээр нэмэгдсэнтэй холбогдуулан хүчин чадал хүрэлцэхгүй байна.

Иймд Монгол улсын Засгийн газрын 2019 оны 08-р сарын 28-ны өдрийн 337 дугаар тогтоолын дагуу тус цэвэрлэх байгууламжийн дэргэд 22 га талбайд шинэ цэвэрлэх байгууламж барихаар төлөвлөсөн.

Төлөвлөгөөт ажлын дагуу 2018.09-р сард Барилга хот байгуулалтын яамнаас Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг барих төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтаар “Чайна Тисижу Сивил Инженеринг Групп” шалгарч гүйцэтгэгчийн ажлыг эхлүүлсэн.

Тус төсөл нь 2019-2023 онуудад зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлыг бүрэн дуусгаж хүлээлгэн өгөхөөр төлөвлөгдсөн боловч 2020-2022 онуудад Ковид-19 цар тахлын улмаас ажлын гүйцэтгэл удааширч 2022-2023 онд байгууламжийг хүлээлгэн өгөх боломжгүй болсон.

Одоогийн байдлаар төслийн талбайд барилга угсралтын үе шат 80 хувьтай хэрэгжиж байгаа тул 2024 оны 4-р улиралд барилга угсралтыг дуусган, тоног төхөөрөмж угсралт, холболтын ажлыг хийхээр төлөвлөж байна. Мөн шинээр гаргалгааны сувгийн ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

1.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлагдах төсөл хэрэгжүүлэх, дараа дараагийн жилүүдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий эрхзүйн баримт бичиг юм.

2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3.4-т “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасны дагуу төсөлд ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж батална” гэж заасны дагуу тус 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОНХС-ын 2014.04.10-ны өдрийн А-117 тоот сайдын тушаал, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу тус тус үндэслэн боловсруулав.

1.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, нийгмийн асуудал, байгаль орчин, тухайн хороонд ажиллаж амьдрах иргэдийн харилцаа хариуцсан нэгж хэсгүүдийн хамтын ажиллагааг хангасан удирдлага зохион байгуулалтын механизмыг хэрхэн бүрэлдүүлж, зардлын төлөвлөгөөг тайлагнахад ашиглагдах баримт бичиг юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төслийн талбай, түүний орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Энэхүү төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- a) Ажиллагсад байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалт, ур чадвартай мэргэжилтэнтэй болсон байна.
- b) Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцож, байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн нөхцөлийг хадгалж хамгаална.
- c) Төсөл хэрэгжиж буй хороо дүүргийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль орчныг хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллана.
- d) Байгаль орчны асуудлаарх төрийн захиргаанаас өгсөн санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллана.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн төслийн БОМТ-тэй танилцан баталж, төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох ба жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж, дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянана. Мөн БОМТ-ний хэрэгжилтэд тухайн нийслэлийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, засаг дарга, БОАЖГ болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй ба тэдгээрт холбогдох мэдээлэл ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг болно.

1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтээр тухайн төслийн:

- a) Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилт: Төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах үйл ажиллагааг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан эсэх,

- b) Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт: Төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх нийт хугацаанд хэрэгжүүлэх орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтээс бүрдэнэ.

БҮЛЭГ 1. ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр: Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Чайна Тисижу Сивил Инженеринг Групп” ХХК

Төслийн зорилго: Улаанбаатар хотын ТЦБ-ын хүчин чадлыг нэмэгдүүлэн, байгаль орчинд үзүүлэх бохирдлын хэмжээг бууруулах, дэвшилтэт технологи инновацид тулгуурлан лагийг дахин боловсруулах, дулаан цахилгаан үйлдвэрлэхэд ашиглах, хаягдал усыг МУ-ын үндэсний стандарт MNS 4943:2015-д нийцүүлж шинээр баригдах ус дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэхэд оршино.

Төслийн хүрээнд 2019 оны 08-р сарын 28-ны өдрийн 337 дугаар МУ-ын Засгийн газрын Улсын тусгай хэрэгцээнд авах тухай тогтоолын дагуу Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Төв цэвэрлэх байгууламжийн дэргэд 22 га газрын аюултай хог хаягдал, лаг боловсруулах, булшлах, устгах байгууламж барих зориулалтаар ашиглахаар төлөвлөсөн.

Төслийн үндэслэл: Одоогийн Төв цэвэрлэх байгууламж нь Улаанбаатар хотын орон сууц, нийтийн байгууламж, үйлдвэр үйлчилгээ гэх мэт төр хувийн хэвшлийн бүх байгууллагуудаас ирэх бохир усыг татаж, цэвэршүүлэн хаягдал усыг Туул гол руу нийлүүлдэг. Одоогийн ашиглаж байгаа ТЦБ нь 1964 онд ашиглалтад орсон, хэд хэдэн үе шаттайгаар өргөжүүлж, цэвэрлэх технологи, тоног төхөөрөмжид сэргээн засварлалт, шинэчлэл хийсэн ч байгууламж нийтдээ хуучирч муудсан тул байгууламжийн доголдлыг бүрэн засварлаж чадаагүй. Бохир ус цэвэрлэх, лаг боловсруулах технологийг шинэчлэх, лагийг хатаах эдийн засгийн эргэлтэд оруулах замаар лаг хадгалах талбайг нэмэгдүүлэхгүйгээр үнэрийн тархалт болон Туул голын экосистемд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, усны нөөцийг нэмэгдүүлэх Тогтвортой хөгжлийн зорилт 2030-ийн “Хуурай газрын экосистемийг хадгалах” зорилтуудыг хангах ажлын хүрээнд тус төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Тус ажлын хүрээнд 2018 оны 09-р сард Монгол улсын Барилга хот байгуулалтын яамнаас Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг барих төслийн сонгон шалгаруулалтыг зарлаж, “Чайна Тисижу Сивил Инженеринг Групп” ХХК оролцож 2019 оны 01-р сард гүйцэтгэгчээр шалгарсан байна.

Төслийн хүрэх үр дүн: Шинэ ТЦБ-ыг барих ажил нь Улаанбаатар хотын усны нөөцийн нэгдсэн менежментийн хувьд маш чухал эерэг нөлөөг бий болгоно. Нөгөөтээгүүр Улаанбаатар хотын нийт хүн ам 1.6 сая-д хүрч төв цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага үүсэж байна.

Хүснэгт 1. Төслийн хүрэх үр дүн


№	Хэрэгцээ	Үр дүн	
		Одоогийн ТЦБ-ын нөхцөл байдал	Шинэ ЦБ барих төсөл
1	Хүчин чадал	160.0-170.0 мян.м3/өдөр	250 мян.м3
		500.0 мян.хүн	1 500.0 мян.хүн
2	Барилга төлөвлөлт	Хуучирч муудсан, засвар үйлчилгээ авах боломжгүй	Барилга байгууламж, тоног төхөөрөмж бүгд шинэ
3	Усны чанар	MNS 4943:2015 стандартад нийцсэн ч органик бодисын цэвэрлэгээ хийгддэггүй.	MNS 4943:2015 стандартад нийцнэ. Цэвэршүүлсэн бохир усыг хэт ягаан туяагаар халдваргүйжүүлнэ.

**“УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЭР БАРИХ” ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Төслийн байршил: Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах одоогийн төв цэвэрлэх байгууламжийн баруун талд



**“УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЭР БАРИХ”
ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРШЛЫН ТОЙМ ЗУРАГ**



Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг

1.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн хүчин чадал нь 250.0 мян.м3/өдөр байх ба үүнээс ахуйн бохир ус цэвэрлэх хэмжээ нь 150.0 мян.м3/өдөр, үйлдвэрийн бохир усыг цэвэрлэх хүчин чадал нь 100.0 мян.м3/өдөр юм.

Шинэ цэвэрлэх байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгснөөр одоо байгаа цэвэрлэх байгууламжийг дахин ашиглахгүй.

Тус төслийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажил дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- ✚ Төв цэвэрлэх байгууламжийн хуучин байгууламжийн бүсэд ахуйн шугамын бохир усны насосны байрыг шинээр барина.
- ✚ Шинээр баригдах төв цэвэрлэх байгууламж: Шинэ цэвэрлэх байгууламж, бохир ус цэвэрлэх байгууламж, бохирын лаг цэвэрлэх байгууламж, үйлдвэрийн урд бүс, нэмэлт барилга байгууламж болон нийт талбайн бусад барилга байгууламж
- ✚ Хаягдал ус зайлуулах шугам хоолой: Шинэ төв цэвэрлэх байгууламжийн гарах ус нь шинээр баригдах эцсийн хаягдал ус зайлуулах шугамаар дамжин Туул гол руу цутгагдана. Хүчин чадал нь 6.65 км байна.

Төслийн гүйцэтгэлийн төлөвлөгөө

Төслийн гүйцэтгэлийн явц нь ТЭЗҮ боловсруулах, үнэлэх, анхан шатны зураг төсөл боловсруулах болон үнэлэх, гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулах, хяналт, төслийн гүйцэтгэл, туршиж ажиллуулах зэрэг үе шатуудаас бүрдэнэ.

Гүйцэтгэгч нь тухайн төслийн зураг, тоног төхөөрөмж худалдан авах болон гүйцэтгэлийн ажлыг хариуцаж, гэрээнд заасан хугацаанд чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэж, төслийн календарчилсан төлөвлөгөөний дагуу ажлыг дуусгахаар гэрээнд заасан байна. Төслийн ажил дууссаны дараа төслийн ажлыг хүлээлгэн өгөх болон нийтэд нь хүлээлгэн өгөх зэрэг ажлуудаас бүрдэнэ.

Хүснэгт 2. Төслийн төлөвлөгөө

№	Үе шат	Анхны төлөвлөгөө	Явц	Эцсийн төлөвлөгөө
1	Анхан шатны зураг төсөл	2019.05	Дууссан	-
2	Гүйцэтгэлийн зураг төсөл	2019.06-12	Дууссан	-
3	Барилга угсралт	2019.09	Үргэлжилж байна.	2024 оны 4-р улирал
4	Тоног төхөөрөмж угсралт	2022	Эхэлсэн	2025
5	Тохиргоо, туршилт	2022-2023	Эхлээгүй	2025
6	Хүлээлгэн өгөх	2023	Эхлээгүй	2025

Төслийн одоогийн нөхцөл байдал

2023 оны 10-р сарын байдлаар төслийн барилга угсралтын үе шат 80 хувьтай үргэлжилж байгаа ба 12 сард 83 хувьд хүргэхээр ажиллаж байна.





Зураг 2. Төслийн талбайн өнөөгийн байдал

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

2.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

Физик газарзүй: Төв цэвэрлэх байгууламжийн талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангайн-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн захын уулсын тойрогт, байгалийн бүс, бүслүүрээрээ ойт хээрийн бүсэд хамаарагдана. Энэ бүс нь хуурайдуу сэрүүн зун, хахир өвөлтэй бүсэд хамрагдана. Энд агаарын температурын сарын дундаж нь 1 дүгээр сард -24.8°C , 7-р сард 16.7°C байдаг бол хамгийн бага утга нь -49.0°C , хамгийн их утга нь 39.5°C , харьцангуй чийгшлийн дундаж 61 хувь, өвөл зуны саруудад жилдээ 2 удаа харьцангуй чийгшлийн их утга ажиглагдаж нэгдүгээр сард 72%, наймдугаар сард 80% байна.

ЦБ-ийн хашаан дотор болоод эргэн тойрны 1, 3,5 км-ийн нөлөөллийн бүс цаашлаад Туул гол дагуу 200 гаруй км буюу Төв аймгийн Лүн сум хүртэлх голын уснаас өмхий үнэр их үнэртдэг.

ЦБ-ийн талбайд гадаргын ус байхгүй бөгөөд гадаргын усны мужлалаар Хойд мөсөн далайн ай сав, Туул голын сав газар, Баянголын дэд сав газарт хамаарагдана.

Хөрсөн бүрхэвч: ЦБ-ийн талбайн хөрс нь Хэнтийн өмнөх тойрогт багтах салбар уулсад хамрагдах бөгөөд тэдгээрийн энгэр хажуу, Туул голын өргөн хөндий орчмын хар хүрэн хөрс зонхилон тархсан байна.

Ургамлан нөмрөг: Н.Өлзийхутагийн Ургамал газарзүйн тойргоор Хэнтийн уулынтайгын тойрогт хамаарагдана. Төслийн талбайн ургамалжилтын хувьд уг газар нь хүний үйл ажиллагааны нөлөөнд өртөөд удаж байгаа ба байгалийн ургамлын унаган төрхөө алдаж хөл газрын ургамал зонхилон ургах бөгөөд энд *Chenopodiumalbum*, *Eragrostismminor*, *Artemisiamacrocephala*, *Urticaungustifoliaper* ургамалтүгээмэл тохиолдож байна.

Амьтны аймаг: Амьтны аймгийн хувьд хүний үйл ажиллагаанд өртөөд удаж байгаа учир амьтны амьдрах орчныг үгүй хийж дүрвэсэн, тухайн орчинд одоогоор шувуудаас оронгийн (*P.domesticus*) ба Хээрийн бор шувуу, Хөхвөр тагтаа (*V.livia*), Сохор элээ(*Milvusmigrans*), Шаазгай (*Picapica*), Улаан хошуут (*Pyrrhocoraxpyrrhocorax*), Хархэрээ (*CorvusCorone*), Хон хэрээ (*Corvuscorax*) тохиолдож байв. Хөхтнөөс гэрийн хулгана нутагшсан.

2.2. НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ

2.2.1. Сонгинохайрхан дүүрэг

Сонгинохайрхан дүүрэгт 9352 өрхийн 32750 хүн оршин суудаг ба хотын хамгийн их хүн амтай дүүрэг юм.

Газрын нэгдмэл сан: Тус дүүргийн газар нутаг нь нийт 120063 га талбайтай үүнээс Хөдөө аж ахуйн газар 86645.90га буюу 72%, Хот тосгон бусад суурины газар 9366.95га буюу 8%, Зам, шугам сүлжээний газар 1444.47га буюу 1%, Ойн сан бүхий газар 21463.41 га буюу 18%, Усны сан бүхий газар 71.00га 0.0005%, Улсын тусгай хэрэгцээний газар 1071.27га 1%-г тус тус эзэлж байна.

2.2.2. Сонгинохайрхан дүүргийн газар ашиглалтын хэмжээ

Улаанбаатар хотын газар нутгийн 325660 га газар нутгаас 167951,6 га буюу 52% -ийг хөдөө аж ахуйн зориулалтаар, 29506.8 га буюу 9%-ийг хот суурин, хотын бусад байгууламжын зориулалтаар, 3993.9 га буюу 1% -ийг тээврийн зам сүлжээ, , 71862.5 га буюу 22% -ийг ойн нөөц бүхий газрын зориулалтаар, 3979.2 га буюу 1% -ийг усны нөөц бүхий газрын зориулалтаар, 48366.0 га буюу 15%-ийг тусгай хэрэгцээний зориулалтаар тус тус ашиглаж нөөцөлдөг байна.

Нөлөөлөл үзүүлэх газар (5 км): Нийт 7853.77 га газрыг хамарч ойр орчимын 5 км зайд идэвхитэй нөлөөлөл үзүүлэгч Бохир ус цэвэрлэх Төв Байгууламжийн хүрээлэлд 23470 объект байрладаг. Нийт газар нутгийн хэмжээнд 1111.76 га буюу 33%-ийг гэр хороолол эзлэх ба 360.92 га буюу 11%-ийг байгууллагын хашаа талбай, 255.16 га буюу 8%-ийг үйлдвэр, 23.99 га буюу 0.3%-ийг сургууль, эмнэлэг, 1427.29 га буюу 42%-ийг тодорхой газарт хамааруулдаг байна.

2.2.3. Хүн амын усны хэрэглээ, хангамж

Ус хэрэглэгч: Улаанбаатар хот 1.4 сая гаруй хүн ам, 20 мянган үйлдвэр, аж ахуйн газар, 400 га усалгаатай газар тариалан, 330 мянган тоо толгой мал сүрэг, 3 цахилгаан станцын усны хэрэгцээг хангадаг. Хотын усны жилийн нийт хэрэглээ нь 77 сая куб метр ба үүний ихэнх хэсгийг хотын ус сувгийн ашиглалтын газраас хангадаг. Ус ашиглалт, хэрэглээний үнэ нь жилд 90 гаруй тэрбум төгрөгт хүрэх ба үүний гуравны хоёрыг унд, ахуйн ус хэрэглэгчид бүрдүүлдэг.

Улаанбаатар хотын газар доорх усны түвшин сүүлийн 50 жилийн туршид буурах хандлагатай байгаа төдийгүй түүний хэрэглээ тэжээгдэлтэй нь харьцуулахад хурдтай өсч байна. Хот хүрээгээ тэлэхийн хирээр усны хэрэгцээ, шаардлага өсөн нэмэгдэж байгаа бөгөөд уг асуудал улам бүр хурцдаж байна.

Одоо байгаа ашиглалтын хурднууд нь бүх хүчин чадлаараа ажиллахад өдөрт 307,000 куб метр ус хэрэглэгдэж байгаа бөгөөд 2020 он гэхэд 438,000 куб метр болох төлөвтэй байгаа бөгөөд 2030 он гэхэд энэ тоо 2 нугалагдаж 614.3 мянгад хүрч болзошгүй байна.

Усны хэрэглээ нь дээрхи хүчин чадлаас давж, улирлын чанартай усны хомсдол аль хэдийн уусч эхэлсэн бөгөөд зарим нэг судалгааны үр дүнгээр 10 ЖИЛИЙН дараа Улаанбаатар хот усны хомсдолд орж болзошгүй байна.

Усан хангамж: Нийслэл хотын Тогтвортой хөгжлийн нэг чухал нөхцөл нь усны нөөц, усан хангамжийн хөгжлийн стратеги юм. Улаанбаатар хотын өргөжин тэлэх хурд, өрсөлдөх чадвар нь өсөн нэмэгдэж буй хүн ам, үйлдвэр, аж ахуйн усны хэрэгцээг тасралтгүй хангах чадвараас шууд шалтгаална. Судалгаагаар өдөрт хэрэглэх усны хэмжээ нь өнөөгийн байдлаар 307 мянган куб метр байгаа бол энэ хэмжээ цаашид 2020 онд 438 мянган куб метр, 2030 он гэхэд усны хэрэглээ одоогийнхоос 2 дахин нэмэгдэж, 614.3 мянган м³/хоног болж өсөхөөр байна.

Улаанбаатар хотыг 2020он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага, Усны өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дараах эх үүсвэрээр хангахаар мастер төлөвлөгөөнд заасан байна. Үүнд:

2030 оны нийт усны хэрэглээний 31 хувь буюу 191.4 мянган м³/хоног усыг дээд ба төвийн эх үүсвэр, гүний усаар хангахаар тусгалаа. Дээд, төвийн эх үүсвэрийн гүний усыг унд ахуйн болон хүнсний салбарын усны хэрэглээнд ашиглах юм.

Туул, Сэлбэ, Улиастай зэрэг голыг түшиглэн усан цөөрөм байгуулна. Ингэснээр Голын урсацыг нөхөн сэргээхийн зэрэгцээ гадаргын усыг нөөцлөн цэвэршүүлж, унд, ахуйн болон ногоон байгууламж /салгаанд ашиглах боломжтой болно. Улаанбаатар хотын 2030 оны усны хэрэглээний 24 хувь буюу 144.5 мянган м³/хоног усыг хангахаар тооцлоо.

Шинээр төлөвлөж буй дэвшилт /нано, био/ технологитой цэвэрлэх байгууламжаас гарах цэвэршүүлсэн усыг саарал ус болгон, 2030 оны нийт усны хэрэглээний 45 хувь буюу 278 мянган м³/хоног усны хэрэглээг хангахаар тусгав.

2.2.4. Аж ахуйн нэгжийн усан хангамж

Улаанбаатар хотод ард иргэдэд үйлчилдэг олон үйлдвэрийн болон үйлчилгээний газар байдаг. Тэдний зарим нь хаягдал усаа стандартын дагуу бүрэн цэвэрлэдэггүй бөгөөд тэрхүү ус БУЦТБ руу очиж нэмэлт ачаалал болдог ба тус байгууламжийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулдаг. Ус Хангамжийн Хэлтсийн статистик мэдээнээс харахад хаягдал усны дийлэнх хэсэг мах, сүү болон арьс ширний үйлдвэрээс, багахан хэсэг нь ариун цэврийн цаасны үйлдвэрээс гардаг байна.

2010 оны статистик мэдээнд нийслэлийн айл өрхийн 40% төвийн цэвэр бохирын шугам сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдардаг байсан бол энэ үзүүлэлт 2018 оны статистик үзүүлэлтээр 5,4 хувиар өссөн байна.

Улаанбаатар хотод Нисэх-Яармаг, Баянголын ам зэрэг тодорхой байршилд нийтийн орон сууцны хороолол шинээр барьж байгуулахаар хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгджээ. Үүнд орон сууцыг худалдаа, үйлчилгээ, нийгмийн дэд бүтэц, авто зогсоолын хамт бичил хорооллын хотхоны/ зохион байгуулалтаар орон сууцны цогцолбор болгон байгуулах, мөн төвийн хэсгийн гэр хороолол болон 1950-60-аад онд барьсан, эдэлгээний хугацаа нь хэтэрч, чанаргүй болсон хотын төвийн орон сууц, нийтийн үйлчилгээний барилгуудыг дахин төлөвлөж, нийтийн орон сууц, олон нийтийн зориулалттай хороолол болгон хөгжүүлэхээр төлөвлөсөн байна. Эл төлөвлөгөө хэрэгжвэл 2010 онд 43,6 хувь байсан инженерийн хангамжтай нийтийн орон сууц 2030 онд 61.8 хувьд хүрнэ.

2.2.5. Гэр хорооллын дахин төлөвлөлт

Хотын зүгээс гэр хороололд дахин төлөвлөлт хийж байршил, инженерийн дэд бүтцийн сүлжээнд холбох боломж, орон сууцны нөхцлөөр нь төв, дунд, зах хэмээн төлөвлөлтийн гурван бүсэд хувааж, шинэчлэн зохион байгуулахыг зорин ажиллаж байна. Үүнд:

Инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох боломжтой төвийн гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөж, өндөр болон дунд давхаржилттай олон нийт, орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ. Энэ бүсэд орших хүн амын усны хэрэглээний хэмжээгээр төвлөрсөн байгууламжаар цэвэрлэх усны хэмжээ нэмэгдэнэ.

Дунд хэсгийн гэр хорооллыг хэсэгчилсэн болон бие даасан инженерийн шугам сүлжээнд холбосон, дунд, нам давхрын сууцны хороолол болгон хөгжүүлнэ. Энэ бүсийн айл өрхийг ойр байршилтай төвлөрсөн сүлжээг өргөтгөх замаар холбох, эсвэл бие даасан Системтэй болгох чиглэл баримтална.

Захын гэр хорооллын хэсэгт газрыг шинэчлэн зохион байгуулж, бие даасан дэд бүтэц бүхийн ам давхаржилттай хувийн сууцны хороолол болгон хөгжүүлнэ. Энэ бүсэд бие даасан систем бий болгох чиглэл баримтална.

2.2.6. Инженерийн дэд бүтцийн төлөвлөлт

Хотын нийтийн аж ахуй хангамж, үйлчилгээний үндсэн тулгуур нь инженерийн дэд бүтэц. Дулаан, цахилгааны эрчим хүч, ундны усны эх үүсвэрийн одоогийн нөөц, хүчин чадал нь нийслэл хотын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ шаардлагаас ихээхэн хоцорч байна. Иймд инженерийн дэд бүтцэд технологийн шинэчлэл хийх, шинэ эх үүсвэр бий болгох нь тулгамдсан хэрэгцээ юм. Одоо ашиглаж байгаа дулаан, цэвэр, бохир усны төвийн шугам сүлжээний дийлэнх нь ашиглалтад орсноос хойш 50 гаруй жил өнгөрч, нэмэгдэж буй хэрэгцээг хангах нь бүхэл ашиглалтаас бүрмөсөн гарах хугацаань аль хэдийн өнгөрсөн байна. Шинэ бүтээн байгуулалт, дахин төлөвлөлт, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан инженерийн дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлэх хэрэгцээ тулгарч байна. Иймд ерөнхий төлөвлөгөөнд ариутгах татуургын талаар дараах чиг хандлага, Шийдэл тусгагджээ.

Улаанбаатар хотод эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхийн тулд одоо байгаа ариутгах татуургын байгууламжуудад шинэ техник технологи түргэвчлэн нэвтрүүлж, дараахи арга хэмжээг авч эрс шинэчлэлт хийгдэнэ. Үүнд:

- ЦБ-д био-нано өндөр технологийн шинэчлэл хийж, хүчин чадлыг хоёр дахин нэмэгдүүлнэ.
- Яармаг хороололд 82512 м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, хотын шинэ төвд цэвэрлэх байгууламж шинээр барьж байгуулна.
- Улаанбаатар хотын бохир ус цэвэрлэх байгууламжын нийт хүчин чадал 266721 м3/хоног болно.
- Туул-1, Толгойт-1 төв коллекторыг ашиглалтад оруулж, Нисэх-Яармаг хороололд 7.8 км бохир усны шугам хоолой шинээр тавина.
- Улаанбаатар хотын ариутгах татуургын төрөл, хамрах хүрээг дараах байдлаар ангилж төлөвлөсөн байна

1-р бүс: Хотын төвийн хэсгийг дахин төлөвлөлтөөр хөгжүүлэхдээ төвлөрсөн сүлжээг өргөтгөж холбох

2-р бүс: Гэр хорооллын төвлөрсөн сүлжээний зарим хэсгийг ойр байршилтай төвлөрсөн сүлжээг өргөтгөх замаар холбох

3-р бүс: Алс зайтай гэр хороолол болон шинэ хотхон хорооллын хувьд төвлөрсөн сүлжээнд холбоход хүндрэл ихтэй, зардал өндөртэй учраас бие даасан системтэй болгох

4-р бүс: Эдгээр бүсийн аль алиныг гадна үлдсэн хэсэг хөрсний бохирдлоос сэргийлэх үүднээс бие даасан ариун цэврийн тоног төхөөрөмж суурилуулах

5-р бүс: Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байгаа 27 зуслан усан хангамж, ариутгах татуургын бие даасан системтэй байхаар төлөвлөв.

2.2.7. Харгиа бохир цэвэрлэх байгууламж

Арьс шир болон ноос ноолуур боловсруулалт нь Улаанбаатар хотын гол үйлдвэрийн салбар юм. Олон тооны арьс ширний үйлдвэрүүд (26) тусгай газарт (Харгиа) төвлөрсөн байх ба бохир ус урьдчилан цэвэрлэх байгууламж мөн тэнд үйл ажиллагаагаа явуулж байдаг. Энэхүү байгууламж нь 2 ноос ноолуур боловсруулах үйлдвэр гэх мэт нийт 25 үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг. Харгиа бохир ус урьдчилан цэвэрлэх байгууламж нь 1972 онд өдөрт 13,000 м³ хаягдал ус цэвэрлэх хүчин чадалтайгаар баригдсан боловч бодит байдал дээр хамаагүй бага (2014 онд дундажаар 2,000 м³/өдөр, 2015 оны эхний 8 сарын байдлаар өдөрт ойролцоогоор 2,350 м³ хаягдал ус урьдчилан цэвэршүүлж байна). Жилийн мөчлөгөөр авч үзэхэд түүхий арьс ширийг үйлдвэрт нийлүүлэх тэр үеэр буюу хэдэн өдрийн турш хаягдал усны урсац хамгийн их буюу 9,000 м³/өдөр байдаг байна. 1993 онд тус байгууламж хувьчлагдаж улмаар 2011 онд УСУГ-ын мэдэлд шилжсэн байна (шилжүүлэх үйл явц 2013 онд эцэс болсон).

Тус байгууламжын одоогын нөхцөл тун хүнд байгаа бөгөөд бохирус цэвэрлэх үр ашиг төлөвлөсөн гүйцэтгэлдээ хүрэхгүй байна. Тус байгууламжыг сэргээн засварлахуу эсвэл шинээр барихуу гэсэн 2 сонголт сүүлийн хэдэн жил яригдсаар ирсэн боловч аль ч хувилбарыг сонгосон ялгаагүй ба учир нь Харгиа цэвэрлэх байгууламжтай холбогдсон үйлдвэрүүдийг хотын гадна нүүлгэн шилжүүлвэл тус урьдчилан цэвэрлэх байгууламжыг татан буулгаж шинэ үйлдвэрийн хаягдал ус цэвэрлэх байгууламжыг нүүлгэн шилжүүлсэн Тэдгээр үйлдвэрүүдийн ойролцоо шинээр барих шаардлага гарна. Үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх асуудал батлагдаагүй байх энэ зуурт Хотын Захиргааны төлөвлөлтийн хэлтэс Улаанбаатар хотын баруун хэсэг буюу Эмээлтэд барих үйлдвэрлэлийн паркард арьс шир болон ноос ноолуурын үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх тухай ТЭЗҮ судалгааг явуулж байна. Үйлдвэрлэлийн Паркийн зэрэгцээ нүүлгэн шилжүүлэх тэдгээр үйлдвэрийн ажилчдыг орон байржуулахын тулд сууршилийн бүсийг мөн хөгжүүлэх шаардлагатай. Үйлдвэрлэлийн паркийн ТЭЗҮ-ийн судалгааг бэлтгэх улсын компани байгуулагдсан ба Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк удахгүй баригдах паркийн үйлдвэрлэлийн хаягдал ус цэвэрлэх байгууламжын ТЭЗҮ-ийн судалгааг одоогоор санхүүжүүлж байна. Эдгээр зохицуулалтууд нь нүүлгэн шилжүүлэх үйл явцыг хэрэгжүүлэх улс төрийн хүсэл сонирхолыг харуулж байна. Үүний зэрэгцээ Арьсны Ширний Үйлдвэрийн Нийгэмлэгн Харилцан ойлголцолын Санамж Бичиг гарын үсэг зурсан нь үйлдвэрийн эзэд Эмээлт рүү нүүхийг зөвшөөрсөнийг харуулж байна. Тиймээс арьс шир болон ноос ноолуур боловсруулах үйлдвэрийг нүүлгэн шилжүүлэх нь БУЦТБ-ын ТЭЗҮ-ийн судалгааны үр дүнд зайлшгүй тусгах боломжит хувилбар юм. 5.1.2.6.2 үйлдвэрийн бохирдлын одоогийн нөхцөл Уналтын явцыг эс тооцвол сүүлийн арваад жил Улаанбаатар хотод үйлдвэрлэлийн салбар эрчимтэй хөгжсөн. Үүнтэй холбоотойгоор үйлдвэрлэлийн усны хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэж улмаар их хэмжээний үйлдвэрийн хаягдал ус хотын бохирын Систем рүү цутгах болсон. Энэ нь 2013 оноос хойшхи БУЦТБ-ын урсацын бохирдол мэдэгдэхүйц нэмэгдсэнийг харуулж байна.

2.2.8. Цэвэрлэх байгууламжаас хүн амд үзүүлж буй нөлөөлөл

Сүүлийн жилүүдэд хүн амын төрөлт нэмэгдэж, хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн тоо өссөнөөс шалтгаалан нийслэл хотын хүн амын өсөлт жил ирэх тусам нэмэгдсээр байна. Үүнийгээ дагаад аж үйлдвэр, бохир усны хэмжээ нэмэгдэж байна.

Статистик судалгаанаас үзэхэд хотын хүн ам тасралтгүй өсөж 2014 онд нийт хүн амын 40 орчим хувь нь орон сууцанд амьдардаг байсан бол 2018 оны байдлаар энэ үзүүлэлт 5,4 хувиар өссөн дүнтэй бана.

ЦБ нь нийт 176271.1 м2 талбайг эзэмшиж уг талбайд үйлдвэрийн бүс байгуулсан. Одоогийн байдлаар уг талбайгаас гадна нийт 476947.9 м2 талбайд ашиглалт явуулж байна.

2.2.9. Хүн амын эрүүл мэнд

Сүүлийн жилүүдэд цэвэрлэх байгууламжтай холбоотой асуудал иргэдийн санал Сэтгэгдэл нийгмийн сүлжээгээр ихээхэн илэрч гомдол сэтгэгдэл ирүүлсний олонхи нь лагийн үмхий үнэрийн талаар дурдсан байна. Мөн Агаар орчны бохирдлоос үүдэлтэй хүн амын өвчлөл халдварт өвчин, амьсгалын замын өвчлөл сүүлийн жилүүдэд нэмэгдэж эмнэлэгт үзүүлэх иргэдийн тоо өсөн нэмэгдэж эрүүл мэндийн байгууллагын ачаалал ихсэж байна.

ЦБ-аас гарч буй үнэрийн тархалтын судалгааг 1, 3, 5 км-ийн бүсэд багтах Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт, нийт 120 иргэн, аж ахуйн нэгжээс санал асуулга авч хийсэн бөгөөд тус судалгаанд оролцогсодоос Сонгинохайрхан дүүрэгт 73 хүн, Хан-Уул дүүрэгт 38 хүн, Баянгол дүүрэгт 9 хүн санал асуулга өгсөн байна.

Лагийн үнэр нь хүний эрүүл мэндэд харшил өгөх, толгой өвдөх, биеийн эсэргүүцэл сулрах, астамтай болох, бие дээр тууралт гарах, жирэмсэн эхийн урагт нөлөөлдөг зэрэг санал их байсан.

Цэвэрлэх байгууламжаас гарах үнэрийн үнэртэх байдлын судалгааны үр дүнгээс харахад Сонгинохайрхан дүүрэгт хамгийн их тархан үнэртдэг байна.

Үнэрийн хяналт. Одоо ашиглагдаж буй цэвэрлэх байгууламж нь хэдийгээр суурьшлын бүсэд оршдог ч орчин тойрондоо эвгүй үнэр тархаан, үнэрийн бохирдол үзүүлэгч томоохон эх үүсвэр болсоор ирсэн ба энэхүү үнэр дараахь 2 үндсэн эх үүсвэрээс улбаатай байна. Үүнд:

- Лаг хатаах талбай дахь хуримтлагдсан багийн хаягдал
- Цэвэрлэх байгууламжийн процесийн үнэр

Лаг хатаах талбайн хуримтлагдсан лагийн тухайд Монгол улсын Засгийн газар болон хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллагууд үе шаттай арга хэмжээ авч ажилладаг.

Одоогийн цэвэрлэх байгууламж гүйцэт цэвэршүүлээгүй бохир ус байгальд нийлүүлгээс улбаалан Туул голын үндсэн бохирдуулагч болж байна. Үүний үндсэн шалтгаан нь i) цэвэрлэх байгууламж хуучирч муудан, цэвэрлэгээний шаардлага хангахгүй болсон ii) бохир усны сүлжээнд нийлүүлэгдэж буй ус стандартын шаардлагад нийцээгүй байдал юм.

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд бий болж буй болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Барилга, хот байгуулалтын яам” захиалагчтай “Чайна Тисижу Сивил Инженеринг Групп” ХХК гүйцэтгэгчтэй “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны ХБОБНУГ-аар баталгаажуулсны дагуу тус төлөвлөгөөний хэрэгжилтийг Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хууль, БОАЖСайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны А-117 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт болон БОАЖ Сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3-р хавсралтын дагуу боловсруулав.

Төслийн 2023 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал 71.426 сая.төг байна.

Хүснэгт 3. 2023 оны БОМТөлөвлөгөөний биелэлтийн зардлын задаргаа

№	Ажлын нэр	Зардал (мян.төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	67 330.0
2	Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал	4 096.0
Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал		71 426.0

3.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хариуг үндэслэн жил бүр шинэчлэн, сайжруулж байх шаардлагатай юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчинд онцгой анхаарал тавьж түүнд нөлөөлж болзошгүй аливаа нөлөөллийг багасгах үүрэгтэй. Үйл ажиллагаагаа явуулж эхлэхээс өмнө өөрийн албан хаагчид болон хамтран ажиллах бусад байгууллагыг байгаль орчин хамгаалах бодлогод хамруулахаар төлөвлөх хэрэгтэй. Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг багасгах, байгаль орчны талаарх дүрэм журмыг биелүүлэх зэргээр өөрсдийн бүх албан хаагчид, гэрээлэгчид өөрсдийн үүргийг биелүүлж ажиллахаар төлөвлөгөөндөө тусгасан байх.

Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөнд байгаль орчин, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний зардал тусган зарцуулж байх шаардлагатай. Төлөвлөсөн зардлын хэмжээ нь тухайн жил бүр харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул тухай бүрд нь тодруулга хийн шинэчлэн тооцно.

Төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардлыг 71.426 сая.төг байхаар тусган оруулсан ба барилга байгууламжийн ажил бүрэн хүчин чадлаараа дуусаагүй тул БОМТ-ын зардалд тусгагдаагүй ажлуудыг 2024 онд хийгдэхээр төсөвт суугдсан.

Хүснэгт 4. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	21 830,0
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	10 100,0
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	11 000,0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	7 400,0
7	Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал	15 000
8	Олон нийтэд танилцуулах	2 000,0

3.2. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Цаашид хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөө: Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны үндсэн бүрдэл хэсгүүд (агаар, ус, хөрс, газрын гадарга, амьтан гэх мэт)–ээр тооцож гаргасан төслийн үйл ажиллагааны хугацаанд биелүүлэх дараах арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулан, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн төлөвлөгөөнд байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан болно.

Хүснэгт 5. 2023 оны байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	БОМТ-ын нийт зардал, мян.төг	БОМТ биелэлтийн хэрэгжилтийн нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	21 830,0	16 760,0
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	10 100,0	-
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	-
4	Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	11 000,0	20 595,878
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	7 400,0	5 511,969
7	Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал	15 000	14 360,0
8	Олон нийтэд танилцуулах	2 000,0	-
	2023 оны БОМТ биелэлтийн хэрэгжилтийн төлбөр	67 330,0	57 227,847

Хүснэгт 6. 2023оны БОМТөлөвлөгөөний биелэлтийн зардлын задаргаа

№	Ажлын нэр	Зардал (мян.төг)	БОМТБ Зардал (мян.төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	67 330,0	57 227,847
2	Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал	4 096,0	4 096,0
	Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал	71 426,0	61 323,847

3.3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Төсөл хэрэгжүүлэгч нь 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Нийт өртөг (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын бохирдлыг бууруулах талаар						
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл	- Агаарын чанарыг хэмжих AQ багаж суурьлуулах (PM10.0, тоосонцор PM 2.5 болон CO ₂ , CO, SO ₂ хэмжих багаж) -ЦБ-ын дотоод, гадаад орчны CH ₄ , CFC хэмжилтыг хийж, ил тод мэдээлэх -Гадаад, дотоод орчны цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийх -Ногоон байгууламжийн талбайн арчилгаа, усалгаа (тарилт, тайралт)	ЦБын дотоод, гадаад орчинд	240.0*4ш	960.0	Өдөр тутам автоматаар мэдээлэл цацна	Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016) MNS 4585 :2007 MNS 0017-2-5-12:1988, Агаар дахь хүхэрлэг хийн хэмжээг тодорхойлох MNS ISO 4221: 2002, Орчны агаарын хүхрийн давхар ислийн агуулгыг тодорхойлох;
	ЦБ-ын гадна болон дотоод орчин дахь үнэрийн тархалтын хяналтын хэмжилт хийх -Үнэрийн хяналтын мэдээллийг олон нийтэд мэдээлдэг байх (цахим хуудас)		200.0*2 удаа	400.0	Жилд 2 удаа	
Бүгд				1 760.0		

**“УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЭР БАРИХ” ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хөрсөн бүрхэвч, газрын доорхи усыг бохирдуулахаас хамгаалах талаар					
Барилгын суурь ухахад өнгөн хөрс устах	Эвдэрч, талхлагдсан газрыг нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлнэ	-ЦБ-ийн үйл ажиллагаа явуулах төлөвлөгөөт талбай -Ашиглахаар тооцоолж тус-гай хэрэгцээнд авсан газарт хамаарна	Үйл ажиллагааны зардалд тусган хэрэгжүүлнэ		Газрын тухай хуулийн 50-р зүйлийн 50.1.1 дэх заалт, 56.6 дэх заалт болон MNS 5918:2008, MNS 5850:2008
Барилга угсралтын ажлын үед ойр орчмын газар элэгдэл, эвдрэлд орох					
Түүхий эд, туслах материал болон шимт хөрсний овоолгын доорх газар талхагдах					
Лагийг цэвэрлэх, хатуу хог хаягдлыг хадгалан тээвэрлэх хүртэл хөрсөнд бохирдол үүсэх	-Хатуу хог хаягдлын цэг байгуулах - Аюултай хог хягдал, химийн бодисын агуулах байгуулах - Лагийн гүний цэвэрлэгээ ариутгал хийх хадгалах үед үүсэх хий, шингэн шүүрлийг хянах, ашиглах, тусгай менежментийг хэрэгжүүлэх, -Аюултай, энгийн, ахуйн хог хаягдлыг нэр төрлөөр нь бүртгэх, ангилах, устгах хяналтын систем бий болгон ажиллах	-Нэг удаа эхний жил -Нэг удаа эхний жил -Лаг цэвэрлэх дамжлагууд -Хог хаягдлыг хадгалах, Ангилах, тээвэрлэх, дамжлагуудын ажлын талбай	Үйл ажиллагааны зардалд тусган хэрэгжүүлсэн.	-Хүйтэн бүсийн бохир усны идэвхтэй лагийг цэвэршүүлэх зураг төслийн стандарт CECS111:2000 -Программчлагдах боломжтой удирдлагын системийн зураг төслийн стандарт HG/T20700-2014 -“Явцын хэмжилт хяналт, удирдлагын төхөөрөм-жийн үйл ажиллагааны таних тэмдэг болон зурган тэмдэглэгээ” HG/T20505-2014	-Автоматжуулсан төхөөрөмжийн сонголт ба зураг төслийн стандарт HG/T20507-2014
Ландфилээс ялгарах хий болон шингэн шүүрэл			Хог ариутгах химийн бодис худалдан авах /ТЭЗҮ-д тооцоолсоноор/ Хог хаягдлын тээвэр ложистикийн зардалд тусган оруулсан Үйл ажиллагааны зардалд тусган хэрэгжүүлнэ.		
Шатах тослох материал алдагдвал газрын хөрс бохирдох	Бохирдсон хөрсийг элс, даавуугаар цэвэрлэх	Бохирдол үүссэн газарт	Үйл ажиллагааны зардалд тусган хэрэгжүүлнэ.		
Бүгд			-		
Гадаргын болон газрын доорх усны бохирдлыг бууруулах талаар					
Усны нөөц, чанарт сэргээр нөлөөлөх	Хаягдал ус цэвэрлэх байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх	ЦБ-ийн барилга байгууламж барих болон ашиглалтын үйл ажиллагаа явуулах	Үйл ажиллагааны зардалд тусган хэрэгжүүлэх	Тогтмол	“Ус хангамж, ариун цэврийн байгуулам-жийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийх заавар” ЭМС, БХБС-ын 2017.04.14-ний өдрийн А/149/78 дугаар хам-тарсан

**“УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЭР БАРИХ” ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

	ЦБ-ийн барилга угсралтын үед барилгын болон тос тосолгооны материал, дизель түлш, хог хаягдлаар бохирдуулахаас сэргийлэх	төлөвлөгөөт талбай	Үйл ажиллагааны зардалд тусган хэрэгжүүлэх	тушаал Усны тухай хууль, 2012 он. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль Ундны усны чанарын стандарт MNS 900:2018 Гүний усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлагууд, MNS 3342:1982 Усны чанар. Гүний усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх агууламж, MNS 6148:2010 ХАБЭА-н ажилтан байнга хяналт тавьж ажиллах
Физик бохирдолыг бууруулах талаар				
Үнэр	-ТЭЗҮ-д тооцоолсоноор ажлын байрны үнэр арилгах тусгай хөтөлбөртэй байх -(Үнэр үүсгэгч аммиак, устөрөгчийн сульфат, Хүхэртэй органик бодис, Азот агуулсан органик биет, Хүчилтөрөгч агуулсан органик биет болон метаны төрлүүд байна.) -Үнэрийг хянах автомат систем, -Агааржуулалтын системийн найдвартай ажиллагаа -(био химийн арга+химийн арга ашиглан үнэр арилгах технологи)	Үйлдвэрийн дотоод орчин, ажлын талбай 1-15 км радиуст	ТЭЗҮ-д төлөвлөсөнөөр байгууламж баригдахдаа анхнаасаа үнэрийн асуудлыг шийдвэрлэсэн технологитой байна. Гэхдээ ХАБ-ийн шаардлагаар өдөр тутам тогтмол хянаж, тэмдэглэл хөтлөх.	-MNS 0012-043:1991, Ажлын байрны агаарын исэлдэх чанарыг тодорхойлох арга; -MNS ISO 16362-2:2003, Гадаад, дотоод болон ажлын байрны орчны агаар – Ууршимтгай органик нэдлүүдийг тодорхойлох хийн хроматографийн арга, -ISO 16017-1:2000, ажлын байрны гад- аад, дотоод орчны -Ууршимтгай органик нэдлүүдийг тодорхойлох хийн хроматографийн арга, 1-р хэсэг, соруулах арга;
Ажлын байр болон орчин тойрны дуу шуугиан, доргилт	-Үйлдвэрийн бүсэд бүтээн байгуулалт явагдах тул ажиллагсадыг хөдөлмөр	Бүтээн байгуулалтын үед	Жил бүр тогтмол үйл ажиллагааны зардалд суулгах	-MNS 0012-9-015-:1987, ХХСС. Ажлын байранд шуугианыг хэмжих арга.

**“УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЭР БАРИХ” ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

	хамгааллын хэрэгсэлээр хангах					-MNS 0012-4-005-:85, Хөдөлмөр хамгаалал, шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд -MNS 4990:2015. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”.
Дамжуулах төхөөрөмжийн ажиллагаа, бохир усны насос, лаг шаврын насос, хайрга цэвэрлэгч төхөөрөмж болон эргэлтийн багажны үйл ажиллагаанаас ажлын байранд дуу шуугиан үүснэ	-Байнгын болон ээлжийн ажилтнуудыг ХАБ, сонсголын аппаратыг хамгаалах хэрэгсэлээр байнга хангах, шалгаж зааварчилгаа өгч байх -Эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт оруулж байх -Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэх	Ажлын байранд	1 хүн 50.0	100 хүн 5 000.0	Жилд 1 удаа	
Ажлын байрны агаарын хэм	-Ажлын байрны температурын зөрөөг бага байлгах үүднээс агаар шүүгч, кондишн, агааржуулагчаар тоноглох. Үүнд: Операторуудын өрөө, сургалтын танхим, эмнэлгийн анхан шатны тусламжийн өрөө, цайны газар г.м/	Ажлын байранд	Төслийн байгууламж барих гүйцэтгэлийн явцад заавал хийх тул хянаж хийлгэхэд анхаарах		1 удаа	MNS 4990:2015. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”.
	Өдөр тутам ээлжийн ажилтнуудад аюулгүй байдлын зааварчилгаа өгөх,		Үйл ажиллагааны зардалд шингэсэн байна			
Бүгд				15 000,0		
Байгаль орчныг хамгаалах нийт зардал				16 760.0		

**“УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЭР БАРИХ” ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хүснэгт 8. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян төг	Нийт зардал мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ажиллагсад болон танилцах аялалын зочид түр саатах ногоон байгууламж бүхий хүлээлгийн талбай	Лагаас гаргаж авсан хөрсөөрөө ногоон байгууламж, туршилтын талбайг байгуулна.	Саравч, явган хүний зам, хогийн сав, сандалтай хамт шийдэх	га	0.6	-		2024 онд	Барилга, хот тохижилтын нэгдсэн хууль журам, стандартаар зоицуулагдана
2.	Байгууллагын эргэн тойрон дуу чимээ, үнэр шингээгч мод бут бүхий ногоон байгууламж, мод үржүүлгийн талбай байгуулах		-Жижиг хүлэмж байхаар төлөвлөнө	га	0.5	-		-Хавар намрын ногоон өдрүүдээр тарилт хийнэ.	
3.	Стандартын тэмдэг, тэмдэглээ бүхий Автомашины зогсоол байгуулах /Ажилчидын тусгай автобустай байна гэж тооцоолов/	ЦБ барихдаа хамтад нь шийдвэрлэнэ	20-30 машины зогсоол	га	0.3	-		Нэг удаа	
4.	1.Орц гарцан дээр ажиллагсад болон зочидыг бүртгэх хянах 2. Өндөрлөгт байрлуулсан харуулын байр		Харуул хамгаалалтын 2 төрлийн байр барих				Төслийн зардлаас	ЦБ барихдаа хамтад нь шийдвэрлэнэ	
Нийт						-			

**“УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЭР БАРИХ” ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

